



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/573

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.ЮНЕСКО-ийн биет бус соёлын өвд бүртгэгдсэн Үндэсний шагайн харвааны спортыг сурталчлах, Сайхан сумын харъяат, Монгол Улсын Үлэмж дархан мэргэн, спортын мастер Лүндэгийн Түвшинжаргалын алдрыг тэмдэглэх зорилгоор зохион байгуулагдаж байгаа баяр наадмын урлаг, соёлын болон спортын арга хэмжээний бай шагналд дэмжлэг үзүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах 10.000.000 (арван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010610